

**Алтай нутаг дахи руни бичгийн
судалгааны товч тойм**

Ц.Баттулга (МУИС)

Алтай нутаг дахи руни бичгийн судалгаа:

- Баян-Өлгий аймгийн нутаг дахи бичээс
- Говь-Алтай аймгийн нутаг дахи бичээс
- Увс аймгийн нутаг дахи бичээс
- Ховд аймгийн нутаг дахи бичээс

Баруун Алтай нутаг эртний түүх соёл, хадны зураг, бичгийн дурсгалаар нэн арвин болохыг өгүүлэх юун. Бид руни бичгийн дурсгалын судалгааны тоймыг товч өгүүлэхийг хичээлээ.

Алтай нутаг дахи эртний үсэг бичгийн дурсгалыг тухайлан судлаж тоймлосон эрдэм шинжилгээний бүтээл энэ хир үгүй юм. Б.Ринчен академич "*Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*" хэмээх ном¹ хэвлүүлсэн нь тухайн үед Монгол нутгаас олдож мэдэгдсэн хадны зураг, тамга, хүн чулуу хийгээд эртний бичиг үсгийн дурсгалыг дотоод, гадаадын эрдэмтэд, судлаач нарт таниулсан анхны бүтээл болсон ажээ. Ялангуяа, Алтай нутаг дахь руни бичгийн зарим дурсгалын талаар анх удаа мэдээлсэн байна². Эрдэмтдийн анхаарал энэ зүг хандсаных буй за, Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги /экспедиц/ (цаашид МЗТСХЭ гэж товчилоно) 1969 оноос эхлэн ажиллах болсон гэдэг.

Олон жил ажилласан тус хээрийн шинжилгээний ангийн, ялангуяа бичээс судлалын хэсгийн ажлын тайлан, эх хэрэглэгдэхүүн ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт бүрэн бүтнээрээ, тэр бүр хадгалагдаж үлдээгүй нь харамсалтай. МЗТСХЭ-ийн "*Бичээс судлал*"-ын хэсэг Б.Ринчен академичийн мэдээллийн мөрөөр Говь-Алтай, Ховд, Увс зэрэг аймгийн нутаг дахи руни бичгийн дурсгалыг газар дээр нь үзэж судалсан ажээ.

¹Rintchen B, *Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*, CSM, Tom. XVI, Fasc. 1, Улаанбаатар, 1968

²Rintchen B, 1968, pp. 38, 39, 41, 43-р тал

Тус хээрийн шинжилгээний ангийн ажлын хүрээнд М.Шинэхүү Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг, Хар Аарагийн бичигт хадны бичээс, Ховд аймгийн Дарви сумын нутаг, Байшин үзүүрийн Жүргэрийн Цагаан Толгойн бичээс зэргийг уншиж судласан байна³.

Ховд аймгийн Ховд сумын нутаг Сонгинотын ар, Өвөр Дөрөлжийн худгийн бичээсийг Б.Ренчин гуайн нийтлүүлсэн гэрэл зургаас сэргээн Б.Базылхан⁴ анх уншсан бөгөөд хожим С.Харжаубай⁵ дурсгалыг биеэр үзэж судлан дахин нийтлүүлжээ. Эл хоёр судалгаанаас үзвэл бичээсийн үсэг тэмдэгт хийгээд уншлага, орчуулга өөр зуураа асар их зөрөөтэй байна. Иймд аль нэг уншлага, орчуулгыг зөв, буруу хэмээн батлан нутлах боломжгүй, бичээсийг дахин уншиж судлах зайлшгүй шаардлагатайг тэмдэглэе.

МЗТСХЭ-ийн бичиг үсэг, хадны зураг судлах хэсэгт ажилласан эрдэмтэн Э.А.Новгородова 1972 онд Ховд аймгийн Үенч сумын нутаг, Ямаан усны хавцлын Ханан хадны руни бичээсийг олж, улмаар Э.Р.Тенишевтэй хамтран уншиж судалжээ⁶. Археологич Ц.Доржсүрэн Увс аймгийн Түргэн сумын нутаг Хар ус хэмээх газар, нутгийн ардууд "Долоогойдой" хэмээн нэрлэх оршуулга булшны томоохон цогцолборт, руни, уйгур бичгээр тус тус бичсэн хоёр хөшөө байсныг 1956 онд олж илрүүлсэн⁷, бөгөөд руни бичээсийг С.Г.Кляшторный⁸, уйгур бичээсийг А.М.Щербак⁹ нарын эрдэмтэд уншиж тайлсан байна. Э.Вандуй уйгур бичээсийн орос орчуулгыг монгол хэлнээ хөрвүүлжээ¹⁰. Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг, Ачит нуурын Шанаган хэв хэмээх газар зэрэгцүүлэн босгосон гурван хөшөөнөө бичиг буйг нутгийнхан мэдээлсний мөрөөр 1979 онд археологич Н.Сэр-Оджав, Д.Дорж нар, 1980 онд МЗТСХЭ-ийн бичиг судлалын хэсэг очиж судалсан байна. Хөшөөний бичээсийг С.Г.Кляшторный¹¹, С.Харжаубай¹² нар тайлан уншжээ. Нэгдүгээр хөшөө эдүгээ Баян-Өлгий аймгийн музейн хашаан дотор буй бөгөөд тээвэрлэн авчрах явцад уг хөшөөний оройн хэсэг хугарчээ. Түүх соёлын дурсгалыг хамгаалах хууль зөрчиж өөр аймгийн нутгаас авчирсан уг хөшөөг музей дотор оруулж хамгаалахгүй бол угаас насжин өгөршсөнөөс элсрэн үйрч буй хөшөө чулуу нар салхи, ус чийгт улам идэгдсээр бичгийн нэгэн дурсгал сүйдэж үгүй болоход хүрсэн байна.

³М.Шинэхүү, Бигэрийн эртний түрэг бичээс. //Шинжлэх ухаан, амьдрал. № 1, Улаанбаатар, 1971, 37-40-р тал; Шинэхүү М, Дарвийн эртний түрэг бичээс. //Studia Archaeologica, Tom. V, Fasc. 3-13, Улаанбаатар, 145-150-р тал

⁴Базылхан Б, Өвөр Дөрвөлжийн түрэг бичээс. //Шинжлэх ухаан амьдрал. №1, Улаанбаатар, 1969, 28-29-р тал

⁵Харжаубай С, Монгол нутгаас шинээр олдсон түрэг бичээсүүд. //Хэл зохиол. XIV боть, 1-19 дэвтэр, Улаанбаатар, 1987, 79-85-р тал

⁶Новгородова Э.А, Тенишев Э, Новые рунические надписи в горах Монгольского Алтая. //История и Культура Центральной Азии. Москва, 1983, стр. 205-208

⁷Доржсүрэн Ц, Долоогойдын булш ба түүний хөшөө. //Шинжлэх ухаан, техник, №5-6, Улаанбаатар, 1957, 25-26-р тал

⁸Кляшторный С.Г, К историографической оценке Уланкомской надписи. //Эпиграфика Востока, 14, Москва, 1961, стр. 26-28

⁹Щербак А.М, Надпись на древнеуйгурском языке из Монголии. //Эпиграфика Востока, 14, Москва, 1961, стр. 23-25

¹⁰Вандуй Э, Увсын Хар Усны гэрэлт хөшөө. //Шинжлэх Ухаан, Техник. № 3(55), Улаанбаатар, 1958, 45-47-р тал

¹¹Кляшторный С.Г, Эпиграфические работы в Монголии. // Археологические Открытия Москва, 1980, стр. 87-89

¹²Харжаубай С, Монгол нутгаас шинээр олдсон түрэг бичээсүүд. //Хэл зохиол. XVI. Боть. 1 Дэвтэр 19, Улаанбаатар, 1987, 79-85-р тал

Нэгдүгээр хөшөөний бичээсийг Туркийн эрдэмтэн Ж.Алялмазын хамт гүймэг уншиж үзэхэд С.Харжаубайн нийтлүүлсэн эхэд зарим үсэг тэмдэгтийг ташаарч буруу уншсан нь илэрхий байсан ба бидний авсан хэв дардаснаа ч тодорхой гарсан буй¹³. Увс аймгийн Сагил сумын нутаг "Төмөр цорго" хэмээх газар, өвөлжөөний хаднаа руни бичээс байхыг археологич Д.Цэвээндорж¹⁴ олж илрүүлснийг Ц.Баттулга¹⁵ уншсан байна. Баруун Алтай дахи эдгээр бичгийн дурсгалын судалгааг доктор Л.Болд өөрийн бүтээлдээ эмхитгэн оруулсан нь¹⁶ эдүгээ чухал эх хэрэглэгдэхүүн болж байгаа билээ.

Алтай нутаг дахи эртний судлал, үсэг бичиг, хадны зургийн судалгаа нэг хэсэг завсарласан ажээ. Харин 1990, 1991 онуудад Баян-Өлгий аймгийн эртний судлалын томъёог зохиох ажлын хүрээнд ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний ажилтан археологич Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар нилээд хэдэн руни бичгийн дурсгалыг шинээр олсныг¹⁷ дурдвал, Ногоон нуур сумын Зүрх уулын бичээс, Дэлүүн сумын төв дэх хөшөөний түрэг бичээс эдгээр болно. Зүрх уулын бичээс судлагдсан ба¹⁸ харин Дэлүүн сумын төвийн бичээсийг энэ хир тайлж уншаагүй байна. Мөн ажлын хүрээнд археологич Д.Эрдэнэбаатар Бугат сумын нутаг дахи Эрэн Харганатын бичээс, Баяннуур сумын Олон нуурын бичээс зэргийг олж илрүүлжээ¹⁹. Монгол Туркийн засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу, Туркийн Олон улстай хамтран ажиллах нийгэмлэгээс санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа "Орхоны хөндий дэх түрээгийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах" төслийн "Бичиг судлал"-ын хэсгийн ажлын хүрээнд 2001 онд Туркийн эрдэмтэн Женгиз Алялмазын хамт Олон нуурын гэрэлт хөшөөг сурвалжлан хүрсэн боловч археологич Д.Эрдэнэбаатарын тайланд хавсаргасан гэрэл болон гар зурагт нийцэх бичиг бус харин хожуу цохисон бололтой нэг мөр бичиг байсныг үзээд эргэлзэхэд хүрсэнээ тэмдэглэх нь зүйтэй болов уу.

¹³Бидний цуглуулгад буй.

¹⁴Цэвээндорж Д. 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманы соёлын дурсгал судлах ангийн тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982; Цэвээндорж Д. Новые надписи Орхоно Енисейской письменности из Цахира и Тумур цорго. //Studia Historica. Tom. VIII, Fasc. 1-13, Улаанбаатар, 124-126-р тал

¹⁵Баттулга Ц, Төмөр цоргын бичээс. //МУИС, Монгол Судлалын Дээд Сургууль. Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть. IX (126), IY дэвтэр, Улаанбаатар, 1997, 22-23-р тал

¹⁶Болд Л, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар, 1990

¹⁷Баяр Д, Баруун Монголд шинээр илэрсэн эртний бичгийн дурсгалууд. //Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, №6, 1990, 37-40-р тал;

Баяр Д, Эрдэнэбаатар Д, ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиллуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1989; Баяр Д, Эрдэнэбаатар Д, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиллуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1990

¹⁸Баттулга Ц, Зүрх уулын бичээс. //МУИС, МСДС, Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть VII, Дэвтэр 6, Улаанбаатар, 1998, 88-90-р тал

¹⁹Эрдэнэбаатар Д, 1990 онд Баян-Өлгий аймгийн нутгаар явуулсан археологийн хайгуулын ангийн тайлан. //ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1991

Бид "Олон нуур"-ын бичээсийг Д.Эрдэнэбаатарын гар хуулбар, гэрэл зурагт тулгуурлан тайлж уншсан билээ²⁰. Эрээн Харганатын бичээсийг археологичдийн гэрэл зураг, гар хуулбарт дулдуйдан уншсан ба уг бичээсийн хэв дардсыг авч дахин нягталсан юм²¹.

ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн ажилтан доктор Д.Цэвээндорж, Америкийн Орегоны Их Сургуулийн профессор Э.Якобсон, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Эртний Судлал-Угсаатны зүйн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор В.Д.Кубарев нарын удирдсан "Эртний Алтай" төслийнхэн Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Бага ойгор, Зүүн оройн өвөлжөөний бичээс, Цагаан нуур сумын нутаг дахи Хар магнайн бичээс зэргийг олж илрүүлжээ²². Баян-Өлгий аймгийн нутгаас олдсон эдгээр бичгийн дурсгалыг Ц.Баттулга судлан эрдэм шинжилгээний цуврал өгүүлэл²³ нийтлүүлжээ. Тэрбээр "Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları" илтгэлдээ Алтай нутгаас шинээр олдсон бичгийн дурсгалын талаар дурдсан байна²⁴.

"Монголын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэвтэрхий толь" зохиох төслийн хүрээнд Соёлын төвийн ажилтан Г.Гонгоржав, Г.Энхбат, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ажилтан доктор Ж.Болд, гэрэл зурагчин Н.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний анги Говь-Алтай аймгийн Чандмань сумын "Шаахар толгой" хэмээх газраас 5 үсэг зурлагатай руни бичээс²⁵ олсныг Ю.Болдбаатар тайлж уншин судалгааны эргэлтэд оруулжээ²⁶. Алтай нутгаас руни бичгийн дурсгал шинээр олдсоор байгаа билээ. Өдгөө шинэ тутам гарч буй эрдэм шинжилгээ, сургалтын ном зохиолд Алтай нутаг дахи руни бичгийн талаархи 1960-80-аад оны судалгааны баримтыг голлон ашиглаж байгаа билээ. Гэтэл зарим бичээсийг уншсан судлаачдын уншлага зөрүүтэй, хуулбар эхүүд маргаантай байгаа нь шинжлэх ухааны баримт болгон ашиглах боломжгүйг харуулж буй хэрэг. Иймд, Алтай нутаг дахи руни бичгийн дурсгалыг өмнөх судалгаатай харьцуулан судлаж дахин нягтлан унших, холбогдох дурсгал, тамга, зураг, булш бунханыг зөв тодорхойлох, эртний бичиг эрэн сурвалжлах, судалгааны эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байна.

²⁰Баттулга Ц, Олон нуурын түрэг бичээс //МУИС, МСДС, Эрдэм шинжилгээний бичиг, Боть XIII (139), дэвтэр 3, Улаанбаатар, 1995, 101-103-р тал

²¹Баттулга Ц, Эрээн Харганатын түрэг бичээс. //Studia Archeologica, Tom. XV, Fasc. 10, Улаанбаатар, 65-70-р тал; Баттулга Ц, Эрээн Харганатын түрэг бичээсийг дахин нягтлах нь. //MONGOLIAN STUDIES. № 10, Сөүл, 2000, pp. 147-153; Баттулга Ц, Төмөр Цоргын бичээс. //МУИС, МСДС, Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть IX (126), Дэвтэр 4, 22-23-р тал

²²Кубарев В.Д. "Магеллан" открывает Алтай. //Рабочая трибуна. 1 Апреля. № 6 (3605), Новосибирск, 1994, стр. 4

²³Баттулга Ц, Хар Магнайн эртний түрэг бичээс. //Studia Archeologica, Tom XIX, Fasc. 11, Улаанбаатар, 1998, 91-93-р тал; Баттулга Ц, Бага Ойгорын эртний түрэг бичээс. //МУИС, ОУХДС, "Алтан аргамжаа", Vol. 2, Улаанбаатар, 1998, 80-84-р тал;

Цэвээндорж Д, Баттулга Ц, Зүүн оройн өвөлжөөний бичээс. //Studia Archeologica, Tom. XV, Fasc. 9, Улаанбаатар, 1997, 98-100-р тал

²⁴Battulga Ts, Moğolistan'da yeni bulunan Göktürk yazıtları. Türk Dili Araştırmaları Yıllığı. BELLETEN 2000, Ankara, 2001, pp. 47-58

²⁵Энхбат Г, Шаахар толгойн хадны зураг. //Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал. Улаанбаатар, 1999, 64-р тал

²⁶Болдбаатар Ю, Шаахарын түрэг бичээс. //ALTAICA I, Улаанбаатар, 2001, 171-173-р тал

Алтай нутаг дахи руни бичгийн дурсгалууд

№	Дурсгалын нэр	Олдсон газар	Судалгаа
Баян-Өлгий аймаг			
1	Бага Ойгорын бичээс	Улаан хус, Бага Ойгор	"Эртний Алтай" шинжилгээний анги, 1994, Ц.Баттулга, 1998
2	Дэлүүний бичээс	Дэлүүн сум, айлын хашаанд буй	Д.Баяр, Д.Эрдэнэбаатар, 1990
3	Зүрх уулын бичээс	Ногоон нуур сум, Зүрх уул	Д.Эрдэнэбаатар 1990, Ц.Баттулга, 1995, 2001
4	Зүүн оройн өвөлжөөний бичээс	Улаан хус, Бага Ойгор	"Эртний Алтай" шинжилгээний анги, 1994, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, 1997
5	Хар Магнайн бичээс	Цагаан нуур сум, Хар магнай уул	"Эртний Алтай" шинжилгээний анги, 1994, Ц.Баттулга, 1997
6	Эрээн Харганатын бичээс	Бугат сум, Хатуугын гол	Д.Эрдэнэбаатар 1990, Ц.Баттулга, 1995, 2001
Говь-Алтай аймаг			
1	Бигэрийн бичээс	Бигэр сум, Хар Аарагийн бичигт хад	Б.Ринчен, М.Шинэхүү, 1971
2	Шаахарын бичээс	Говь-Алтай, Чандмань сум, Шаахар толгой	Г.Гонгоржав, Г.Энхбат, Ж.Болд 1996, Болдбаатар, 2000
Ховд аймаг			
1	Дарвийн бичээс	Дарви сум, Байшин үзүүрийн Жүргэрийн Цагаан Толгойн хад	Ринчен, 1968, М.Шинэхүү, 1972
2	Ханан хадны бичээс	Үенч сум, Ямаан усны хавцалын Ханан хад	А.Новгородова, 1972 А.Новгородова, Э.Тенишев, 1983
3	Өвөр Дөрөлжийн бичээс	Ховд сум, Сонгинотын ар, Өвөр Дөрөлжийн худаг	Б.Ринчен, 1968, Б.Базылхан, 1969 С.Харжаубай, 1987
Увс аймаг			
1	Ачит нуурын бичээс	Бөхмөрөн сум, Ачит нуурын Шанаган хэв. //I хөшөөнөөс бусад нь уг газраа буй	Н.Сэр-Оджав, Д.Дорж, 1979, С.Г.Кляшторный, 1980 С.Харжаубай, 1987
2	Долоогойдойн бичээс	Түргэн сум, Хар усны Долоогойдойн булш. //Улаангомьн музейд хадгалагдаж байна.	Ц.Доржсүрэн, 1956, А.М.Щербак, 1961, С.Г.Кляшторный, 1961
3	Төмөр Цоргын бичээс	Сагил сум, Төмөр цоргын өвөлжөө	Д.Цэвээндорж, 1981 (1982) Ц.Баттулга, 1997

Ном зүй

Базылхан Б. Өвөрдөрвөлжийн түрэг бичээс. //Шинжлэх Ухаан, Амьдрал, №1, Улаанбаатар, 1983

Баяр Д. Баруун Монголд шинээр илэрсэн эртний бичгийн дурсгалууд. //Шинжлэх Ухааны Академийн Мэдээ, №6, Улаанбаатар, 1990

Баяр Д., Эрдэнэбаатар Д. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиллуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1989

- Баяр Д, Эрдэнэбаатар Д**, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн нутагт томилон ажиллуулсан археологийн шинжилгээний ангийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1990
- Баттулга Ц**, Олон нуурын түрэг бичээс. //МУИС, МСДС, Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть XIII (139), дэвтэр 3, Улаанбаатар, 1995
- Баттулга Ц**, Эрээн Харганатын түрэг бичээс. *Studia Archaeologica*, Tom. XV, Fasc. 10, Улаанбаатар, 1995
- Баттулга Ц**, Зүрх уулын бичээс. //МУИС, МСДС, Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть VII, Дэвтэр 5, Улаанбаатар, 1990
- Баттулга Ц**, Төмөр Цоргын бичээс. //МУИС, МСДС, Эрдэм Шинжилгээний Бичиг, Боть IX (126), Дэвтэр 4, Улаанбаатар, 1990
- Баттулга Ц**, Хар Магнайн эртний түрэг бичээс. //Studia Archaeologica, Tom. XIX, Fasc. 11, Улаанбаатар, 1997
- Баттулга Ц**, Бага Ойгорын эртний түрэг бичээс. //МУИС, ОУХДС, Алтан аргамжаа, Vol. 2, Улаанбаатар, 1998
- Баттулга Ц**, Эрээн Харганатын түрэг бичээсийг дахин нягтлах нь. //MONGOLIAN STUDIES, 10, Сөүл, 2000
- Battulga Tsend**, *Mongolistan'da yeni bulunan Göktürk yazıtları. //Türk Dili Araştırmaları Yıllığı. BELLETEN 2000, Ankara, 2001*
- Болд Л**, БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар, 1990
- Болд Л**, Орхон бичгийн дурсгал II. Улаанбаатар, 2000
- Болдбаатар Ю**, Шахарын түрэг бичээс. //ALTAICA I, Улаанбаатар, 2001
- Вандуй Э**, Увсын Хар усны гэрэлт хөшөө. //Шинжлэх Ухаан, Техник № 3(55), Улаанбаатар, 1957
- Доржсүрэн Ц**, Долоогойдойн булш ба түүний хөшөө. //Шинжлэх Ухаан, Техник № 5-6, Улаанбаатар, 1957
- Кубарев В.Д.**, "Магеллан" открывает Алтай. //Рабочая трибуна. 1 Апреля. № 6(3605), Новосибирск, 1994
- Кляшторный С.Г.**, К историографической оценке Уланкомской надписи. //Эпиграфика Востока 14, Москва, 1961
- Кляшторный С.Г.**, Эпиграфические работы в Монголии. //Археологические Открытия, 1976, Москва, 1977
- Кляшторный С.Г.**, К историографической оценке Уланкомской надписи. //Эпиграфика Востока 14, Москва, 1961
- Rintchen B**, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, CSM, Tom. XVI, Fasc. 1, Улаанбаатар, 1968
- Тенишев Э, Новгородова Э.А.**, Новые рунические надписи в горах Монгольского Алтая. //История и культура центральной Азии, Москва, 1983
- Харжаубай С**, Монгол нутгаас шинээр олдсон түрэг бичээсүүд. //Хэл Зохиол, Боть XVI, 1-19-р дэвтэр, Улаанбаатар, 1987
- Цэвээндорж Д**, 1981 онд Увс, Хөвсгөл аймагт ажилласан Чандманы соёлын дурсгал судлах ангийн тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1982
- Цэвээндорж Д**, Новые надписи Орхоно-Енисейской письменности из Цахира и Тумур Цорго. //Studia Historica. Tom VIII, Улаанбаатар, 1980
- Цэвээндорж Д, Энхбат Б**, Увс аймгийн нутгаар хийсэн археологийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1987
- Цэвээндорж Д, Баттулга Ц**, Зүүн Оройн өвөлжөөний бичээс. //Studia Archaeologica, tom. XV Fasc. 9, Улаанбаатар, 1997
- Шинэхүү М**, Бигэрийн эртний түрэг бичээс. //Шинжлэх Ухаан, Амьдрал № 1, Улаанбаатар, 1971
- Шинэхүү М**, Дарвийн эртний түрэг бичээс. //Studia Archaeologica, Fasc. 1-13, Улаанбаатар, 1972
- Щербак А.М.**, Надпись на древнеуйгурском языке из Монголии. //Эпиграфика Востока № 14, Москва, 1961
- Эрдэнэбаатар Д**, 1990 онд Баян-Өлгий аймгийн нутгаар явуулсан археологийн хайгуулын ангийн тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1991
- Энхбат Б**, Увс аймгийн нутгаар хийсэн археологийн ажлын тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1990
- Энхбат Б**, Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн тайлан. //Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан, Улаанбаатар, 1987
- Энхбат Г**, Шахар толгойн хадны зураг. //Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах). Улаанбаатар, 1999